



ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/119

Сайншанд сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1. Дорноговь аймгийн ЗДТГ-ын дээвэр, гадна фасадны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: У.Баярбилэг /Орон нутгийн өмчийн газрын дарга/

Нарийн бичгийн дарга: П.Уянга /Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн/

Гишүүд:

М.Мөнхбаясгалан /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн зам тээвэр, эрчим хүч, харилцаа холбооны бодлого хариуцсан мэргэжилтэн/

Б.Билэгдэлгэр /Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн/

Э.Уранчимэг /Иргэний төлөөлөл/

2. Дээрх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичиг бэлтгэх, тендерийг хянан хүлээн авах, үнэлгээний хорооны дүгнэлт гаргах ажлыг хуулийн дагуу цаг хугацаанд нь зохион байгуулах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, тендер шалгаруулалтын шударга байдлыг хангаж ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЭНХТҮВШИН

44 1 20 0207